



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 87.

Есөнбулаг сум


Болзол батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үхэр сүрэг өсгөж, ашиг шимийг нэмэгдүүлэх уралдааны болзлыг 1 дүгээр хавсралтаар, үхэрчний анкетыг 2 дугаар хавсралтаар, шалгаруулах ажлын үзүүлэлтийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Болзлыг дүгнэн шалгаруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах, болзлыг бүх сумдад хүргэж, хэрэгжилтийг хангаж, хугацаанд дүгнэж шалгаруулахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Баян-эрдэнэ/ нарт даалгасугай.

3. Уг тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2012 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 16 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

22

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 09
дүгээр сарын 04-ний өдрийн 87-р
тогтоолын 01-р хавсралт



ҮХЭР ӨСГӨХ УРАЛДААНЫ БОЛЗОЛ

Нэг. Үндэслэл:

Говь-Алтай аймгийн үхэр сүрэг 1980 онд хамгийн олон буюу 99.4 мянган толгой хүрч байсан бол 2002 оны зуданд 16.5 мянга, 2010 оны зуданд 18.3 мянган толгой болон буурсан. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 16 дугаар тогтоолоор үхэр өсгөх уралдааны болзол зарлан хэрэгжүүлсэнээр 2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 71.0 мянган толгой үхэр тоологдож, 3.8 дахин өссөн боловч нийт сүргийн 2 хувийг эзэлж байна. Дээрх байдалд дүгнэлт хийж үхэр сүргийг байгалийн эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, нийт үхэр сүргийг махны чиглэлийн хээлтүүлэгчээр сайжруулах, тоо толгойг нэмэгдүүлэх, шаардлагтай гэж үзэн үхэр сүрэг өсгөх уралдааны болзлыг шинэчлэн боловсруулаа.

Хоёр. Зорилго

Үхэр сүргийн тоо толгойг өсгөж, үүлдэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэхэд идэвх санаачлага гарган ажиллаж байгаа үхэрчдийг дэмжиж урамшуулахад уралдааны зорилго оршино.

Гурав. Шалгуур үзүүлэлт

3.1. Тодорхойлогдож байгаа үхэрчин дараах нийтлэг шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

3.1.1. Үхэр сүргээ сүүлийн 2 жил дараалан өсгөж, зүй бус хорогдол гаргаагүй байх.

3.1.2. Оны эхний 100 үнээ тутмаас 80-аас доошгүй хувиар тугал бойжуулсан байх.

3.1.3. Орон нутгийнхаа байгаль, цаг агаарын онцлогт тохирсон ашиг шим арвинтай үржлийн шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчээр үхэр сүргийнхээ чанарыг сайжруулсан байх.

3.1.4. Улс, бүс, орон нутгийн чанартай үзэсгэлэн худалдаанд үржлийн шилмэл мал болон бүтээгдэхүүнээрээ идэвхтэй оролцдог байх.

3.1.5. Цөөн үхэртэй 2-оос доошгүй малчин өрхийн амьжиргааны түвшинг сайжруулахад 2-оос цөөнгүй үржлийн үхрээр дэмжлэг үзүүлсэн байх.

3.1.6. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, шимтгэл төлсөн байх.

3.1.7. Малын индексжүүлсэн даатгалд нийт үхэр сүргийнхээ 25-аас доошгүй хувийг хамруулсан байх.

3.1.8. Малын хулгайн гэмт хэрэгт холбогдоогүй байх.

Дөрөв. Материал бүрдүүлэх

4.1. Үхэрчинг тодорхойлохдоо багийн Иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг үндэслэн сумын аварга малчин болсон, болзлын шалгуур үзүүлэлтийг хангасан үхэрчдийг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн нэг үхэрчинг шалгаруулж, хүсэлтийн хамт аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад жил бүрийн 01 дугаар сарын 05-ны дотор ирүүлсэн байна.

4.2. Үхэрчинг тодорхойлохдоо дараах материалыг бүрдүүлнэ.

- 4.2.1. Үхэрчний товч анкет /Хавсралт 2/
- 4.2.2. Үхэрчний ажлын үзүүлэлт /Хавсралт 3/
- 4.2.3. Үхэрчний ажил байдлын тодорхойлолт
- 4.2.4. Багийн Иргэдийн нийтийн хурлын тогтоол, тэмдэглэл
- 4.2.5. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр
- 4.2.6. Холбогдох байгууллага, аж ахуй нэгж, иргэний гаргасан баталгаа
- 4.2.7. Үхэрчний ажлыг газар дээр нь шалгасан сумын Засаг даргын тамгын газрын дүгнэлт, фото зураг

4.3. Тодорхойлолтод энэ болзлын 3-т заасан шалгуур үзүүлэлтийг дараах байгууллага, албан тушаалтан баталгаажуулж, баримтаар нотолсон байна.

- 4.3.1. Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга 4.2.4;
- 4.3.2. Сумын Засаг даргын тамгын газар 4.2.1, 4.2.2, 4.2.3, 4.2.5, 4.2.7;
- 4.3.3. Сумын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч 3.1.6;
- 4.3.4. Тухайн даатгалын байгууллага 3.1.7;
- 4.3.5. Цагдаагийн хэсгийн төлөөлөгч 3.1.8;

Тав. Уралдааныг дүгнэх


5.1. Аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага сумдаас ирсэн үхэрчдийн материалыг нэг бүрчлэн хянаж энэхүү болзлын шалгуур үзүүлэлтийг хангасан үхэрчдийн материалыг ажлын үзүүлэлтээр нь эрэмбэлэн 14 хоног багтаан Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

5.2. Үхэр сүрэг өсгөх уралдааны болзлыг хамгийн сайн хангасан 1 үхэрчинг шалгаруулж “Аймгийн аварга малчин” цол /үнэмлэх, энгэрийн тэмдэг/ олгож шагнана.

Зургаа. Шагнал олгох

6.1. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө гардуулна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны...
дүгээр сарын ...-ний өдрийн...-р
тогтоолын...-р хавсралт




ҮХЭРЧНИЙ ТОВЧ АНКЕТ

Зураг

1	Аймаг, сум, багийн нэр	
2	Ургийн овог	
3	Эцэг /эх/-ийн нэр	
4	Нэр	
5	Төрсөн он, нас, хүйс	
6	Боловсрол	
7	Ам бүлийн гишүүдийн тоо, тэдний эрхэлж байгаа ажил	
8	Улсад ажилласан хугацаа, хийж байсан ажил	
9	Малчнаар ажилласан хугацаа	
10	Төр, засгаас авсан шагнал, огноо	

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны...
дүгээр сарын ...-ний өдрийн...-р
тогтоолын...-р хавсралт



ҮХЭРЧИН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлтийн нэр	... он	... он	... он
1	Оны эхний үхрийн тоо			
2	Нийт үнээ тоо			
3	Үнээний эзлэх хувь			
	Бухны тоо			
4	Үүнээс худалдан авсан бухны тоо /үүлдэр/			
5	Оны эхний үнээнээс бойжуулсан тугал			
6	Малжуулахад өгсөн үхрийн тоо			
7	Зүй бусаар хорогдсон үхэр			
8	Малын даатгал /мян.төг/			
9	Эрүүл мэндийн даатгал /мян.төг/			
10	Нийгмийн даатгалын шимтгэл /мян.төг/			
11	Үзэсгэлэн худалдаанд оролцсон байдал			